

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/7

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.VII	2023.VII	2024.VI	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	16.4	13.6	-	-	-	-	5.6% ▲
Инфляц	хувь	5.5	9.2	5.1	0.1% ▲	-	4.4% ▲	-3.7 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2024 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2024 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1573	1360	1287	286 ▲	-	-	213 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3380.65	3442.35	3381.19	-0.25 ▼	-	-	-61.49 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	2854	3675	2507	-	-	-	-820 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	46.1	35.4	39.4	-	-	-	10.7 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	927.6	891.3	785.2	-	-	-	36.3 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	11%	13%	11%	-1%	-	0%	-2%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.37	3.83	4.84	-2.1% ▼	-	-	23.7% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.87%	8.77%	5.84%	0.03 нэгж хувиар ▲	-	-	-2.90 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 99 мянга гаруй байгууллагын 85% нь 1-9 ажилтантай байна.	Хуулийн этгээдийн 193.9 мянга буюу 78.9% нь компани, 32 мянга буюу 13% нь Төрийн Бүс Байгууллага, 7 мянга буюу 2.9% нь хоршоо, 5.4 мянга буюу 2.2% нь нөхөрлөл, 5 мянга буюу 2% нь төсвийн байгууллага, 2.5 мянга буюу 1% нь ТӨҮГ, ОНӨҮГ буюу бусад байна.
--	--

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Бодлогын хүүг 11% хэвээр үлдээв.	2024/07/02	Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 6 дугаар сарын 25, 7 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 5.5 хувь, өмнөх оны эцсээс 4.4 хувь, өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна. 2024 оны 7 дугаар сард Хангайн бүсэд барааны бүлгийн үнэ 7.4 хувь, Баруун бүсэд үйлчилгээний бүлгийн үнэ 7.9 хувь, Хангайн бүсэд хүнсний бүлгийн үнэ 8.7 хувь, хүнсний бус бүлгийн үнэ 6.5 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 7 дугаар сард 3380.86 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 61.49 төгрөгөөр, өмнөх сараас 0.25 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -2.1%-р буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 23.7%-р өсөж, 4.37 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 17.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.7 (36.5%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 16.8 их наяд төгрөгт хүрч, 4.4 (35.3%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 7 сард 15.3 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 7 сард нийт 153 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 15.7 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 9.3 тэрбум ам.доллар, импорт 6.4 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 2.9 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.0 (14.2%) тэрбум ам.доллар, экспорт 567.3 (6.5%) сая ам.доллар, импорт 1.4 (27.6%) тэрбум ам.доллароор тус тус өсөж, тэнцэл 820.6 (22.3%) сая ам.доллароор буурсан байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 7-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 7-р сар 2024 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn